



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 529

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Дундговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 85 дугаар тогтоол, Өмнөговь аймгийн Засаг даргын 2019 оны А/684, А/753 дугаар захирамж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дундговь, Өмнөговь аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр бий болсон 3 нэрийн нийт 109,960,000.00 (нэг зуун есөн сая есөн зуун жаран мянган) төгрөгийн балансын үнэ, 22,000,000.00 (хорин хоёр сая) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу төрийн өмчид хүлээн авч, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа байгууллагуудад эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Д.Загджав, тогтоолд заасан харьяа байгууллагын дарга болон Дундговь, Өмнөговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001511

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны дугаар сарын 08-ны өдрийн
99 дугаар тогтоолын хавсралт

ДУНДГОВЬ, ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙГ ТӨРИЙН ӨМЧИД
ХҮЛЭЭН АВЧ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬАА БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрө)	Нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шилжүүлэн авах байгууллагын нэр
1.Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар								
1	Албан конторын газар	м2	1020	23,460,000.00	23,460,000.00	-	23,460,000.00	Өмнөговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
	Дүн				23,460,000.00	-	23,460,000.00	
1	Тоёота харриэр, 00-09 ӨМЭ	ш	1	37,000,000.00	37,000,000.00	-	37,000,000.00	Өмнөговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
	Дүн				37,000,000.00	-	37,000,000.00	
	Нийт дүн				60,460,000.00		60,460,000.00	
2.Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар								
1	Тоёота ландкирейзер-100, 00-05 ДУА	ш	1	49,500,000.00	49,500,000.00	22,000,000.00	27,500,000.00	Дундговь аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
	Нийт дүн				49,500,000.00	22,000,000.00	27,500,000.00	
	Бүгд дүн				109,960,000.00	22,000,000.00	87,960,000.00	
					(нэг зуун есөн сая есөн зуун жаран мянга)	(хорин хоёр сая)	(наян долоон сая есөн зуун жаран мянга)	